

Э. Геттиер. ***Зөвтгөгдсөн үнэн үнэмшил мэдлэг мөн үү?***

Орчуулсан: **С.Бүжинлхам**, докторант, багш
МУИС, Философи, шашин судлалын тэнхим
Э.Хулан, докторант
БНХАУ, Шаньдуны Их сургууль

Сүүлийн үед аливаа этгээд тухайн хэллэгийг мэддэг байхад шаардах зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөлийг тайлбарлах янз бүрийн оролдлого бий болов. Ихэнх оролдлогыг дараах маягаар илэрхийлж болохуйц байна.¹²⁸

- (a) IFF (Зөвхөн)^{***}
- (i) P(хэллэг) нь үнэн байх,
(ii) S(Субъект) P(хэллэг)-д үнэмшсэн байх,
(iii) S(Субъект) P(хэллэг)-д үнэмших үнэмшил нь зөвтгөгдсөн байх
- Үед л S (Субъект) P(хэллэг)-ийг мэддэг.

Тухайлбал, Чисхолм дараах шаардлага мэдлэгийн зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй байх нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзжээ.¹²⁹

- (b) IFF (Зөвхөн)
- (i) S (Субъект) P (хэллэг)-ийг хүлээн зөвшөөрсөн байх
(ii) S (Субъект) нь P (хэллэг)-ийн талаар хангалттай нотолгоотой байх,
(iii) P (хэллэг) нь үнэн байх
- үед л S (Субъект) P (хэллэг)-ийг мэддэг.

Айер мэдлэгийн зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл дараах хэлбэртэй байхаар тодорхойлжээ.¹³⁰

- (i) IFF (Зөвхөн)P (хэллэг)нь үнэн байх
(ii) S(Субъект) P (хэллэг)-ийг үнэн гэдэгт эргэлзэхгүй байх
(iii) S(Субъект) P (хэллэг)-ийг үнэн гэдэгт эргэлзэхгүй байгаа нь зөв

* Edmund L. Gettier, Is Justified True Belief Knowledge?, Analysis, Volume 23, Issue 6, June 1963, Pages 121–123, <https://doi.org/10.1093/analys/23.6.121> — Орч.

** 2021 оны гуравдугаар сарын 23-ны өдөр Америкийн философич Эдмунд Геттиер (1927-2021) таалал төгсөв. Тэрээр 36 насандаа буюу 1963 онд алдарт Анализ сэтгүүлд энэхүү гурван нүүр Зөвтгөгдсөн үнэн үнэмшил мэдлэг мөн үү? хэмээх өгүүлэл нийтлүүлснээр алдар хүндийг олжээ. Түүний академик нөлөө бараг бүхэлдээ энэ өгүүлэлээс улбаатай гэж үзэж болно. Учир нь тэрээр амьдралынхаа туршид ердөө хоёр өгүүлэл, нэг шүүмж бичсэн байдаг аж. Э. Геттиер Зөвтгөгдсөн үнэн үнэмшил мэдлэг мөн үү? өгүүлэлдээ хоёр төрлийн тохиолдлыг жишээ болгон авч, мэдлэгийн тухай уламжлалт үзэл санаа буюу мэдлэгийн анализыг няцаасан байдаг билээ. Улмаар энэ нь уг сэдэвтэй холбогдох олон маргааныг дагуулж ирсэн бөгөөд өнөө хэр судлагдсаар байна. — Орч.

*** Өгүүлэл дэх IFF(if and only if) буюу зөвхөн... бол гэх энэхүү холбоос нь эквиваленцийн (biconditional) холбоос бөгөөд зайлшгүй болон хүрэлцээтэй нөхцөл зэрэг хангасан гэх нөхцөлийг илтгэнэ. — Орч.

¹²⁸ Платон Теэтэт 201-т иймэрхүү маягийн тодорхойлолтын талаар авч үзсэн байдаг бөгөөд Мено 98-д үүнийгээ бараг зөвшөөрсөн бололтой байдаг.

¹²⁹ Roderick M. Chisholm, Perceiving: a Philosophical Study, Cornell University Press (Ithaca, New York, 1957), p. 16. Родерик М. Чисхолм, Мэдрэхүй: Философийн нэгэн судалгаа, Корнеллийн ИС-ийн хэвлэлийн газар (Итака, Нью-Йорк, 1957), 16 дахь тал.

¹³⁰ A. J. Ayer, The Problem of Knowledge, Macmillan (London, 1956), p. 34.

А. Ж. Айер, Мэдлэгийн асуудал, Макмиллан хэвлэлийн газар (Лондон, 1956), 34 дэх тал.

үед л S(Субъект) Р (хэллэг)-ийг мэддэг.

Энд илэрхийлсэн нөхцөлүүд нь S(Субъект) Р(хэллэг)-ийг мэддэг гэх хэллэг үнэн байх *хүрэлцээтэй* нөхцөлийг бүрэлдүүлэхгүй байгаа тул би (a)-г худал гэж үндэслэх болно. “гэх хангалттай нотолгоотой байх”, “гэдэгт эргэлзэхгүй байгаа нь зөв” гэдгээр “гэдэг үнэмшил нь зөвтгөгдсөн байх”-г бүрэн орлуулах аваас (b) болон (c) ч бас бүдэрнэ гэдгийг мөн л ижил үндэслэлээс харж болно.

Би эхлээд хоёр зүйлийг онцолъё. Нэгдүгээрт S(Субъект) Р(хэллэг)-ийг мэддэг байх зайлшгүй нөхцөл болох S(Субъект)-ийн Р(хэллэг)-ийн талаарх үнэмшил зөвтгөгдсөн байх гэдгийн “зөвтгөгдсөн” гэх утгын хувьд тухайн хүний үнэмшиж, үнэмшлээ зөвтгөсөн хэллэг баримтын хувьд худал байх бололцоотой. Хоёрдугаарт, ямар ч Р-хэллэгийн хувьд, S(Субъект) Р(тухайн хэллэг)-ийн талаарх үнэмшлээ зөвтгөж, Q(дүгнэлт) нь Р-ийн мөрдлөгөө болж, S нь Р-ээс Q(дүгнэлт)-ийг дедукцэлж, мөн Q(дүгнэлт)-ийг энэхүү дедукцийн үр дүн хэмээн үзвэл Q(дүгнэлт) -ийн талаарх S(Субъект)-ийн үнэмшил зөвтгөгдөх болно. Эл хоёр санааг мартахгүй байхыг сануулж байна. Ингээд би (a)-д дурдсан нөхцөлүүд нь үнэн байх хэдий ч тухайн этгээд уг хэллэгийг мэднэ гэдэг нь худал байх зарим хэллэгийг дараах хоёр тохиолдлоор харуулъя.

Тохиолдол I:

Смит, Жонес хоёр нэг албан тушаал дээр ажиллах хүсэлт өгчээ гэж бодъё. Улмаар Смитэд дараах нэгдмэл(конъюнктив)**** хэллэгийг нотлох тун баттай нотолгоо байна:

(d) Тэрхүү албан тушаал дээр ажиллах хүн бол Жонес, мөн Жонесын халаасанд 10 ширхэг зоос бий.

Компанийн захирал Жонесыг эцэст нь сонгоно гэдгийг Смитэд хэлсэн, бас Смит 10 минутын өмнө Жонесын халаас дахь зоосыг тоолсон нь Смитэд байгаа (d)-ийн нотолгоо байж болох юм. (d)-хэллэгээс дараах хэллэг мөрдөгдөн гарна:

(e) Халаасандаа 10 ширхэг зоостой хүн тухайн ажилд орно.

Смитийг (d)-ээс (e) гарах мөрдлөгөөг мэдэж байсан гэж төсөөлцгөөе. Түүнчлэн (e)-г хүлээн зөвшөөрөх нь түүнд буй баттай нотолгоо бүхий (d) дээр тулгуурласан билээ. Энэ тохиолдолд Смитийн (e)-д үнэмших үнэмшил нь маш тодорхой зөвтгөгдсөн байна.

Гэвч цааш төсөөлцгөөе. Тухайн ажилд орох хүн нь Жонес биш, өөрөө гэдгийг Смит мэдэхгүй байгаа. Мөн тэрээр өөрийнхөө халаасанд 10 ширхэг зоос байгаа гэдгийг ч бас мэдэхгүй. Тэгвэл (e) хэллэг үнэн боловч Смит (e)-гийн үндэслэгээ болгосон (d) хэллэг нь худал гэсэн үг. Тэгэхээр бидний эл жишээнд дараах хэллэгүүд бүгд үнэн байна: (i) (e) нь үнэн, (ii) Смит (e)-г үнэн гэдэгт үнэмшсэн, (iii) Смитийн (e)-г үнэн гэдэг үнэмшил зөвтгөгдсөн. Гэхдээ үүний нэг адил илэрхий байгаа зүйл бол Смит (e)-г үнэн гэдгийг *мэдэхгүй* байгаа явдал юм. Учир нь (e) нь Смитийн халаас дахь зоосны тоонд үндэслэн үнэн байх бөгөөд Смит өөрийн халаасанд хэдэн ширхэг зоос байгааг мэдэхгүй. Смитийн (e)-ийн талаарх үнэмшил Жонесын халаас дахь зоосны тоонд үндэслэсэн бөгөөд түүнийг ажилд орно хэмээн үнэмшсэн түүний үнэмшил алдаатай байна.

Тохиолдол II:

Дараах бодомжийн талаарх тун баттай нотолгоо Смитэд бий гэж бодъё:

(f) Жонесд Форд загварын машин бий.

Смитийн санаж байгаагаар Жонес өдийг хүртэл машинтай байсан, тэр нь Форд загварын машин байсан төдийгүй Жонес саяхан Смитийг өөрийн унаж буй Форд машинаараа хүргэж өгсөн гэдэг нь Смитийн нотолгоо байж болох юм. Одоо Смитэд Браун гээд бас нэг найз байдаг гэж

**** Нэгдмэл буюу конъюнктив хэллэг (бодомж) бол бүрдүүлж буй энгийн хэллэг тус бүр нь нэгэн зэрэг үнэн байхад үнэн, бусад тохиолдолд худал байдаг хэллэг юм. — *Орч.*

төсөөлцгөөе. Смит Брауныг хаана байгаа талаар юу ч мэдэхгүй. Смит санамсаргүйгээр гурван газрын нэр сонгож, дараах гурван хэллэгийг хэлье:

- (g) Жонесд Форд загварын машин байдаг эсвэл Браун Бостонд байгаа;
- (h) Жонесд Форд загварын машин байдаг эсвэл Браун Барселонад байгаа;
- (i) Жонесд Форд загварын машин байдаг эсвэл Браун Брест-Литовскд байгаа.

Эдгээр бүх хэллэг нь (f)-ийн мөрдлөгөө байна.^{*****} Смит эдгээр хэллэгийн мөрдлөгөөг (f)-д үндэслэн босгож буйгаа ойлгож, улмаар (f)-д тулгуурлан (g), (h), болон (i)-г хүлээн зөвшөөрч байна хэмээе. Смит өөрт буй баттай нотолгоо бүхий хэллэгээс (g), (h), болон (i)-ийн талаар оновчтой гаргалгааг хийсэн байна. Тиймээс Смит эдгээр гурван хэллэгийн алинд ч үнэмших үнэмшлээ бүрэн зөвтгөж болно. Мэдээж Брауныг хаана байгаа талаар Смит огт мэдэхгүй.

Одоо дахиад хоёр шинэ нөхцөл бий төсөөлье. Нэгдүгээрт Жонес Форд загварын машин *эзэмидэггүй*, одоо барьж байгаа машин нь түрээсийн машин. Хоёрдугаарт цэвэр тохиолдлоор (h) хэллэгт дурдсан газар үнэхээр Браун байгаа бөгөөд Смит энэ талаар огт мэдэхгүй. Хэрэв энэ хоёр шинэ нөхцөл биелэх аваас, хэдийгээр (i) (h) *үнэн*, (ii) Смит (h) үнэн гэдэгт үнэмшсэн, (iii) Смитийн (h) үнэн гэдэг үнэмшлийг зөвтгөж болох боловч Смит (h) -ийн үнэн гэдгийг ерөөс мэдэхгүй.

Энэхүү хоёр жишээ нь хэн нэгэн өгөгдсөн хэллэгийн талаар мэдэхэд (a) тодорхойлолт *хүрэлцээтэй* нөхцөл болж чадахгүйг харуулж байна. Зохих өөрчлөлт хийсний хойно үүнтэй ижил тохиолдлууд (b) тодорхойлолт эсвэл (c) тодорхойлолт аль нь ч байсан мөн л (a) тодорхойлолтын нэг адил хүрэлцээтэй нөхцөл болж чадахгүй гэдгийг хангалттай харуулах юм.

Вэйн Мужийн Их Сургууль

^{*****} (g), (h), болон (i) бодомж буюу хэллэгүүд нь заагт(дизъюнктив) хэллэг билээ. — Орч.